

СЭТГҮҮЛ ЗҮЙН БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ, ЗҮЙЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД
“МОНГОЛЫН ҮНЭН” СОНИНЫ ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Т.Баасансүрэн*

*Улаанбаатар-Эрдэм Оюу” Их Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), профессор

Түлхүүр үг. “Монголын үнэн” сонин, бичлэгийн төрөл зүйл, аян замын тэмдэглэл, чөлөөт сэтгэлгээ, алтан үеийнхэн, уран чадвар, шүүмж судлал

Монголд тасралтгүй гарсан цорын ганц сонин. “Үнэн” сонин бол Монголд сүүлийн нэг бүтэн зууны турш тасралтгүйгээр хэвлэгдэн гарч байгаа цорын ганц хэвлэл. Ийм урт насыг насалсан өөр сонин Монголд байхгүй. Бусад хэвлэлээс үүгээрээ онцгойрон ялгарч байна. Тэр хэмжээгээрээ ч монголын тогтмол хэвлэлийн хөгжилд оруулсан түүний гавьяа зүтгэл нь тодорхойлогдоно.

Өөр нэг өвөрмөц содон ялгарах онцлог нь гэвэл яах ч аргагүй “Үнэн” сонинд үе үеийн шилдэг сэтгүүлчид ажиллаж хөдөлмөрлөж, сэтгүүл зүйн шилдэг нийтлэлүүдээ өргөн олон түмэндээ эл сониноор дамжуулан танилцуулж ирсэн үнэт өв уламжлал юм. Өөрөөр хэлбэл “Үнэн” сонин нь Монголын үе үеийн шилдэг зохиолч, сэтгүүлчдийг өсгөж хөгжүүлж, уран бүтээлийн хувьд эрийн цээнд хүргэжээ. Эдүгээ ч тэрхүү уламжлал арилж алга болоогүй хэвээр үргэлжилж байна. Ийм бахархалт зуун жилийн түүх өөр

Монголын нэг ч сонин, сэтгүүл, мэдээллийн байгууллагад байхгүй юм.

2004 онд хэвлүүлсэн “Үнэн-20000” хэмээх эмхэтгэлд манай ахмад сэтгүүлч Х.Цэвлээ “Үнэн” сонинд ажиллаж байсан үе үеийн сэтгүүлчдийг “Алтан үеийнхэн”, “Ахмад үеийнхэн”, “Дунд үеийнхэн”, “Орчин үеийнхэн” гэж дөрөв хувааж нэрлэсэн байгаа юм¹.

Алтан үеийнхэн. Жагсаалтын тэргүүнд нь хувьсгалын удирдагч Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, С.Данзан, Д.Лосол, Д.Ишдорж, С.Буяннэмэх, Ц.Дамбадорж, Ж.Цэвээн, Б.Намсрай, Д.Нацагдорж, Дорж Мээрэн, зураач Пунцагжунай, Б.Шарав, Г.Навааннамжил, Сүхбаатарын Янжмаа, Б.Элдэв-Очир нарын нэрс бичигдэж байдаг нь тус сонины нэн хүндэтгэлтэй бөгөөд бахархалтай түүхэн замналыг гэрчилнэ гэж тэр бээр тодотгожээ.

Ар талаас Ө.Бадрах, Мэнд, Малж.Мижиддорж, Наваан, Бага Самдан, Банзрагч, Бадамжав, Гонгоржав, Цэндсүрэн, Дугаржав, Амарсайхан, Цэндсүрэн, Базарсүрэн, Наваанлуvsан, Дуламжав, Чагнаасүрэн, Цогтзана, Жавдал, Шагдар, Самдан, Өлзий-Очир, Чойндон, Дашгомбо, Балдан, Цэдэнжав, Жамъян, Амарсайхан, Ч.Дашням, Ц.Дамдинсүрэн, Дүгэржав,

Мишиг, Пүрэв, Сосорбарам, Найдан, Сэрээтэр, Лувсандорж, Дагдан, Лувсандагва, Ядамсүрэн, Шаравдоо, Дагваторж, Даваасүрэн, Бат-Очир, Одсэрбарзар, Балжир, Баяртсайхан зэрэг улс төр, нийгэм-соёл, утга бичгийн нэрт зүтгэлтэн хүмүүсийн нэр жагсан бичигдэнэ гэжээ.

Үе үеийн “Үнэн” сониныхон эдгээр сэтгүүлчдийн бүтээлээс нь суралцаж өөрсдөө улам шамдан бичиж дараа дараагийнхандаа дамжуулан өвлүүлж ирсэн байж таарна. Ингээд бодохоор монголын утга зохиол, сэтгүүл зүйн сод авьяастнуудын уран чадвар, урлах эрдэм нь “Үнэн” сонинтой бүх талаар нягт холбоотой байна, түүний үлгэр дуурайл нь бусад сонин хэвлэлийн нийтлэлийн бодлого, үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлж иржээ гэж хэлж болохоор байна.

Миний бие “Монголын үнэн” сонины 6 дугаарыг 1920 онд хилийн чанадад биечлэн эрхэлж гаргасан С.Буяннэмэхийн талаар дагнасан судалгаа хийж “Сономбалжирын Буяннэмэхийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ” хэмээх 29,5 хэвлэлийн хуудас ном бичиж 2019 онд нийтийн хүртээл болгосон билээ. Анхных нь эрхлэн гаргагчийн тухай ийм бүтээл туурвиж болж буй юм чинь бусдынх нь талаар мөн адил олон зүйл хэлж болох нь ойлгомжтой юм.

Х.Цэвлээ гуай “Алтан үеийнхэн”-тэй залгуулаад “Ахмад үеийнхэн” хэмээн гарчиглажээ. Тэр хэсгийг уншиж сонирхож үзвэл дор дурдсан сэтгүүлчдийн нэрс дурайж байна.

Ахмад үеийнхэн. С.Дашдэндэв, Ц.Дамдинсүрэн, С.Удвал, Л.Цэнд-Очир, М.Бизьяа, Ц.Цэдэнжав, Ш.Нацагдорж, Б.Бааст, Ч.Лодойдамба, Л.Бадарч, Дүгэрсүрэн, Сүрьяа, Балдансэнгээ,

Содном, Г.Жамц, О.Пунцаг, Н.Циенжав, Г.Дэчингунгаа, Г.Бидэрьяа, Б.Дашдорж, Даржаа, Б.Ринчен, Даваа, Лувсандорж, Лувсансанж, Д.Норовжанчив, Содномбалжир, С.Чимиддамба, Дэчинжав, Баасан, Г.Содов, Лувсанбалжир, У.Лувсан, Ж.Санжаа, Б.Самдан, Х.Намсрайжав, Ц.Банзрагч, Г.Содов, Ж.Санжаа, Д.Цэрэндорж, Н.Иштавхай, Далай, Д.Даш, Яринпил, Батсангас, Дагдандорж /гэрэл зурагчин/, Д.Чимиддорж, Шарав-Иш, Дамдин, А.Мядагмаа, С.Бадраа, Бирваа, Д.Цэрэндагва, Д.Үржинбадам, Баатарчулуун, М.Цэдэндорж, Г.Дэлэг, Ц.Самдандаш, С.Пүрэвжав, С.Дугуйцагаан, Д.Тарва, Л.Содов, Д.Абмэд, О.Цэрэндорж, О.Сумъяа, Даг.Жамьян, М.Чойжил, М.Гүрсэд, М.Долгорсүрэн, Ж.Жоож, Л.Чойжилжав, Г.Рагчаа, Ж.Үүрцайх, Я.Санжайжав, Ч.Буджав, С.Цэвэг, Г.Гомбо, Т.Должин, Б.Дашцэрэн, Б.Шаравнямбуу, Д.Уданбор, С.Жамсран, С.Рэнчинсамбуу, Д.Сүрэнжав, Ч.Чимэд, И.Дамбажав, С.Чулуунцэрэн, Ц.Гайтав, Ч.Бавуу, И.Гүрринчин, Ж.Ринченмядаг, Ж.Зундуй, Г.Адьяа, Д.Жадамбаа, Н.Жамбалсүрэн, Ч.Жамбалсүрэн, О.Нямсүрэн, Балжинням нарын зэрэг нэрт сэтгүүлч сурвалжлагч ажилтнууд “Үнэн” сонинд ажиллаж байсан байна. Энд 98 сэтгүүлчийн нэрийг иш татжээ.

Энэ олон зохиолч, сэтгүүлчдийн уран бүтээлээр монголын хэд хэдэн үеийнхэн хүмүүжсэн гэж хэлэхэд хэн маргах билээ.

Дунд үеийнхэн. 1960, 1970, 1980, 1990-ээд онд Б.Дамдинсүрэн, Н.Цагаач, Лувсанжамц, М.Лхагвасүрэн /фото/, С.Авирмэд, Дорж, Н.Намдагсүрэн, Ц.Дашдорж, Л.Түдэв, М.Цэрэнжамц /фото/, Г.Ёндонжамц, Ж.Риймэд, Б.Жамд, Н.Цэвэгмид, С.Доржпалам, А.Чойжилжав, Г.Очирбат, Ц.Намсрай,

Ц.Мишигдорж, С.Жамбалдорж, Г.Дашцэрэн, Д.Шагдарсүрэн, Г.Ринчинсамбуу, Ц.Рэнчин, Чимэдрэгзэн, Д.Дарамбазар, Д.Дорждулам, О.Хахаар, Д.Нямсүрэн, Төмөрбат, Ц.Онон, Пүрэвбаатар, А.Дамдинсүрэн, Ч.Түмэндэлгэр, Ж.Цэрэнпунцаг, Лхамжав, Ц.Чиваажижий, Б.Ганбат, Ц.Ванчиндорж, Ц.Дамдинжав, Жам.Шагдар, Б.Цэрэндаш, Д.Самбуупунцаг, Дэнсээхүү, Р.Хаянхярваа, С.Гүнрэгжав, Х.Силам, Шагдарсүрэн, А.Гүрсэд, Ц.Рэнцэн, Ш.Дулмаа, Г.Дамба, Р.Чулуун, Ногоя, Т.Дамдин, Ц.Дашдондов, Г.Жамсранжав, Д.Сэнэднасаа, Ц.Мөнхбаатар, Б.Амгалан, Ч.Арьяасүрэн, Г.Бямбажал, Ш.Цэнд-Аюуш, Б.Ламсүрэн, М.Жадамбаа, Т.Баасансүрэн, Л.Бат-Өлзий, П.Төмөрбаатар, Г.Чулуун, Ц.Балдорж, Жа.Пүрэв, Л.Дашням, Н.Бөхдамбий, Л.Нямготов, С.Уртнасан, И.Батсүх, Го.Жамц, Л.Батсүх, Х.Чулуунгомбо, Р.Гээлий, Төмөрбаатар, Ш.Цэрэнпил, Т.Дамбадаржаа, Ёндонравцаг, Б.Ганболд, Н.Шарав, Ө.Тогоо, Д.Цэвлээ, Х.Цэвлээ, Ш.Сандаг, С.Лочин, Х.Ганбат, Ч.Цанжид, До.Цэнджав, А.Даваасамбуу, Далантай, Ч.Наранцэцэг, Т.Баатар, Ч.Эрдэнэ, Б.Базаррагчаа, Б.Цэнддоо, С.Батмөнх, Х.Чойжилжав, Андрууш, До.Дамдинсүрэн, Сундуй, Чулуунбаатар, В.Гончигсүрэн, С.Цацралт, Д.Эрдэнэчимэг, Далантай, Ж.Дулмаа, Б.Бямбаа, Батжаргал, Ц.Доржготов, Ц.Байды, Ж.Лхагваа, Б.Догмид, Т.Нэргүй, Доржпагма, Ш.Цэен-Ойдов, Жанчив, Жан.Шагдар, Ө.Тогоо, Т.Цоож, Д.Тунгалаг, Мэндбаяр, Н.Шүрээ, П.Төмөрбаатар, Д.Батмөнх, Б.Монголхүү, Р.Энхбат, Ч.Сувд, Ц.Энхчимэг, Н.Байгальмаа, Ж.Бадамсүрэн, М.Лхагвасүрэн, Ж.Дулмаа, Ж.Барамсай, Д.Цэрэнжав, Ш.Бадарч, Л.Дашням, Д.Хүрэлбат, Бямбаа, Бямбажав, Бямбадорж, Ж.Галданцогт, З.Пүрэв,

И.Батсүх, Л.Батсүх, С.Надмид, Ц.Ундрах, Баярмаа, Д.Бодьгэрэл, Цэрэндорж, Сундуй, Н.Дуламсүрэн, Ш.Бадамханд, Л.Өлзийбат, Ерэнтэй, Юндэндорж, С.Цогтбаяр нарын зэрэг олон ажил мэргэжлийн хүмүүс үнэний төлөө их үйлст гар санаа нэгдэн ажиллаж байжээ. 162 хүнийг нэрлэсэн байна.

Орчин үеийнхэн. Ө.Энхтүвшин, Г.Дамба, Н.Шарав, Жа.Пүрэв, С.Лочин, Г.Жамсранжав, Ц.Мишигдорж, Л.Нямготов, Г.Жамц, Ж.Галданцогт, Т.Бямбадорж, Ш.Цэрэнпил, До.Цэнджав, Х.Ганбат, Н.Бөхдамбий, Я.Даваа, Андрууш, Р.Энхбат, Лха.Дарьсүрэн, Ж.Бадамсүрэн, Ч.Наранцэцэг, Ц.Хасбаатар, Ш.Бадарч, Б.Энхбат, Балж.Ганбат, Б.Ойдов, Ж.Бадарч, С.Хишигсүрэн, Ч.Содномдорж, Го.Энхтөр, Ш.Гүндалай, С.Товуудорж, Б.Энхтуяа, Д.Батмөнх, Б.Буянцог, Ч.Баяртогтох, Б.Гантуяа нар “Үнэн” сонины наян жилийн ой хүртэлх хугацаанд ажиллаж байв гэжээ. 37 хүн байна. Энэ бол “Үнэн” сонины 80 жилийн ойн үеэр нэрлэсэн нэрс.

Ө нөөдөр 100 жилийнх нь ой болж байна гэж бодоход өнгөрсөн 20 жилд дор хаяхад зуугаад хүн нэмэгдэж таарна. Ш.Цэрэнпил, До.Цэнджав, Г.Жамц, Ч.Содномдорж... гээд уншигчдын танил нэрсийг жагсаан бичжээ. Ш.Цэрэнпилийн хөргүүдийг, До.Цэнджавын уянгын нийтлэлүүдийг, Г.Жамцын асуудал дэвшүүлсэн өгүүлүүдийг, Ч.Содномдоржийн шуурхай сурвалжилга, нийтэд тархсан дуунуудыг олон хүн мартаагүй санаж байгаа байхаа.

Зөвхөн дээр нэр дурдсан бүтэн дөрвөн үеийнхний 400-500 орчим хүний “Үнэн” сонинд нийтлүүлсэн бүтээлүүдийг эмхэтгэхэд хэдэн арав, зуун боть болно.

Зарим нийтлэлийн уран чадварын асуудлыг зориуд хөндөн үе үеийн төлөөллөөс нэр заан өгүүлэх нь. Анх ханын сонинд гарсан түүхтэй Д.Нацагдоржийн “Миний нутаг” хэмээх алдарт шүлэг л гэхэд “Үнэн” сонинд нийтлэгдсэнээр Монголын ард түмний хүртээл болжээ. Ийм жишээ баримт нэг биш, нэг хэсгийг хэлж болно.

Одоо “Үнэн” сонин Монголын сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлийг хөгжүүлж төлөвшүүлэхэд ямар үүрэг гүйцэтгэж ирсэн талаар цөөн үг хэлье. Манай сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл дотор хаан ширээнд залардаг нь товч мэдээ.

“Үнэн” сонин товч мэдээг хөгжүүлж төлөвшүүлсэн нь. “Үнэн” сонины 1921 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн дугаарт “Дотоодын сонин” гэсэн товч мэдээ нийтлэгджээ. “Саяхан Ховдын хязгаараас ирсэн цахилгаан мэдээг авч байцаан үзвээс тэнд ардын нам, засгийн төлөөлөгч Хасбаатар, Дамбадорж нар хувьсгал үүсгэн, хязгаарын албаны газар байгуулж буй бөгөөд тэргүүлэгч нь Дөрвөд далай хаан, Цэргийн жанжин нь Хасбаатар, дотоод хэргийг эрхлэн, ардын намын үзлийг дэлгэрүүлэгч нь Дамбадорж нар болой хэмээмүй. Ховд хотоос зугтаасан цагаан намын заналт хулгай Конгордов нарыг жанжин Хасбаатараар монгол цэргийг дагалдуулан мордож хөөн гаргав хэмээмүй. Жич тэмдэглэх нь: Дөрвөд далай хаантан, ардын намын сургаалыг сүсэглэн дагаж өөрийн хаан зэргийг устгатугай хэмээн байгаа бөгөөд хязгаарын хэргийг бүрэн бүтэн болгож сайжруулахыг хичээн буй хэмээжээ”.

Дөрөвхөн өгүүлбэр бүхий эл мэдээ 99 жилийн тэртээд буюу 1921 онд Ховдын хязгаарт болж өнгөрсөн цэрэг дайны холбогдолтой нэгэн чухал үйл

явдлыг алган дээр авчран тавьсан адил тод томруун өгүүлж байна. Ардын нам, засгийн төлөөлөгч Хасбаатар, Дамбадорж нар Ховдын хязгаарт хувьсгал үүсгэж хязгаарын засаг захиргааг байгуулж буйг дурдаад тэргүүлэгчээр Дөрвөд далай хааныг элсүүлж авч, цэргийн жанжин нь Хасбаатар, дотоод хэргийг эрхлэн ардын намын үзлийг дэлгэрүүлэгч нь Дамбадорж нар болохыг мэдээлсэн байна.

Хаант Оросын цагаан намын заналт хулгай Конгордов нарыг жанжин Хасбаатараар удирдуулсан монгол цэргүүд Ховд хотоос үлдэн хөөж гаргав гээд жич тэмдэглэх нь хэмээх сүүлчийн өгүүлбэрт Дөрвөд далай хаантан ардын намын сургаалыг сүсэглэн дагаж өөрийн хаан зэргийг сайн дураар устгаад шинэ засгийн үйл хэрэгт зүтгэлцэж хязгаар нутгийг илбэн тохинуулж сайжруулахыг хичээн байна гэжээ. Уг товч мэдээний шуугиан дуулиантай сонирхол татахуйц хэсэг нь энэ юм. Дөрвөд далай хаан хүртэл Ардын намын суртлыг сүсэглэн дагаж, өөрийн хаан зэргээ сайн дураар устгаад Ардын засгийн үйл хэрэгт идэвхийлэн зүтгэж эхэлснийг мэдээлсэн байна.

Уруугаа харсан пирамид буюу хэзээ, хаана, юу болов хэмээх сэтгүүл зүйн товч мэдээний сонгодог асуултад мөн адил сонгодог хариултыг өгч чадсан байна. Энэ баримт нь бидний өвөг дээдэс, тухайлбал “Үнэн” сонины 1921 оны ажилтнууд нийтлэлийн бичлэг, ялангуяа товч мэдээний талаар гүн гүнзгий өндөр мэдлэгтэй, сэтгүүл зүйн үйл ажиллагааны багагүй дадлага туршлагатай байсныг батлан харуулж байгаа юм. Харамсалтай нь мэдээ бичсэн зохиогчийн нэр алга. Тэр үед нэргүйгээр эсвэл нууц нэрээр бүтээл туурвилаа сонин хэвлэлд нийтлүүлэх нь түгээмэл байжээ.

1945 оны №169-д хэвлэгдсэн “Эрдэмтэн болов” хэмээх 3 өгүүлбэрт мэдээнд залуу сэхээтэн Н.Жагварал ЗХУ-д сургууль хийж эдийн засгийн ухааны кандидат эрдэмтний цолыг Москвад авав. Энэ бол монгол хүн анх удаа эрдэмтний зэрэгт хүрч эрхэм цолыг авсан тэмдэглэлт үйл явдал болов гэж мэдээлсэн байна. Эл мэдээ уншигчдад:

1. Монгол Улсад ард түмний сурах эрхийг хуулиар баталгаажуулж бага, дунд, их сургуулийг байгуулснаар ардын залуус эрдэм номд шамдах сайхан боломжийг бүрдүүлсэн гэжээ.
2. Залуу сэхээтэн Н.Жагварал ЗХУ-д сургууль хийж эдийн засгийн ухааны кандидат эрдэмтний цолыг Москва хотноо авлаа гэсэн байна.
3. Энэ нь монголчуудаас анх удаа эрдэмтний зэрэгт хүрч эрхэм цолыг авсан тэмдэглэлтэй үйл явдал боллоо гэсэн аж.
4. Эдгээр гурван зүйлийн мэдээллээс дутахгүй цохон тэмдэглэх ёстой өөр нэг баримт бол уг үйл явдлын талаарх товч мэдээллийг “Үнэн” сонины 1945 оны №169-д сурвалжлагч Н.Цэенжав гэдэг хүн бичжээ гэсэн мэдээлэл болно.
5. Энд нэг зүйлийг тодотгож хэлье. Монгол Улсаас анх төрж гарсан эрдэмтэн бол ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн болтлоо өгсөж дэвшиж дорно дахиныг судлагчдын дунд ихэд нэр хүндийг олж хүлээн зөвшөөрөгдсөн Жамсраны Цэвээн юм. Гэвч түүнийг “пан Монгол”-ын үзэлтэн гэж хэлмэгдүүлж бүтээл туурвил, нэр усыг нь ил дурддаггүй байсан 1945 онд Н.Жагваралыг Монголын анхны эрдэмтэн гэж Н.Цэенжав сурвалжлагч нэрлэснийг буруутах үндэслэлгүй юм.

6. “Үнэн” сонин нь сэтгүүл зүйн төрөл, зүйлийг Монголд хөгжүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлсэн хүндтэй хэвлэл яах ч аргагүй мөн бөгөөд товч мэдээний төрөлд товойж ялгарч байсан том уран бүтээлчдийн нэг нь Н.Цэенжав мөн билээ. Энэ сонинд 1961 оны 4-р сарын 12-нд нийтлэгдсэн “Огторгуйн уудамд анх удаа хүн ниссэн тухай” гэсэн гарчигтай МОНЦАМЭ-гийн товч мэдээ, эл үйл явдлаас хорин жилийн дараа буюу 1981 оны 3-р сарын 22-ны өдрийн “Үнэн” сонинд гарсан “Олон улсын баг тойрог замд” хэмээх гарчигтай Владимир Жанибеков, Жүгдэрдэмидийн Гүррагчаа нар сансарт ниссэн, БНМАУ өөрийн иргэнийг сансарт илгээсэн улс гүрнүүдийн жагсаалтад багтаж, Ж.Гүррагчаа хүн төрөлхтний түүхэнд сансарт ниссэн 101 дэх иргэнээр бүртгэгдсэн тухай ТАСС-МОНЦАМЭ-гийн хамтарсан мэдээ нь “Эрдэмтэн болов” хэмээх дээрх мэдээний нэгэн адил “Үнэн” сонины алтан фондод үүрд хадгалагдан үлдсэн үнэт чухал мэдээллүүд юм.

“Үнэн” сонин ярилцлагын жанрыг хөгжүүлсэн нь. Дээрхийн нэгэн адил “Үнэн” сонины ярилцлагын төрөлд онцгойрон ялгарч үлдсэн өөр нэг үнэт бүтээл бол МУСГЗ, сэтгүүлч Жа.Пүрэвийн “Ц.Балхаажав: Таслалын гайгаар Ю.Цэдэнбалын өмнө цаг зогсож байлаа” ярилцлага болно.

Уг ярилцлагыг зохиогч Жа.-Пүрэв өгөөжтэй, үнэмшилтэй болгохын тулд хэд хэдэн хүчтэй баримтаар шигтгэж тодотгож өгсөн нь уншигчдын нүдийг соронздон татаж байна. Тэдгээр шигтгээнээс хоёрхныг иш татъя.

Ц.Балхаажав тэнхимийн сурагч байхдаа нэг найзтайгаа хоршооны хогон дээрээс 20 мөнгө олж хоёулаа папирос тамхи худалдан аваад

сургуулиас зайдуу хүнээс нуугдан байж уралдаж татаад ухаан балартан бөөлжиж сургуулийн галч Намсрай гуайд нэг нэг алгадуулаад аяга аяга сүү цутгуулан ууж хордлого тайлагдсан. Энэ нь түүний тамхи татах анхны бөгөөд эцсийн сургамж болсон тухай, сумын бичиг үсгийн багш нарын курст аймагт сууж төгсөх үед нь хүн бүрээс 5 төгрөг хураан авч орой нь сайн багш болохын тулд хүн бүр шаазан аяга архиар шахуулж уугаад ухаан алдаж, тэр нь түүний хувьд мөн л эхний ба эцсийн согтолт байсан тухай Жа.Пүрэвийн энэ ярилцлагад гарч байна. Эдүгээ 92 насыг зооглоод буй, манай улсын хүн судлалын салбар дахь нэртэй том эрдэмтэн, Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор профессор Ц.Балхаажавтай сэтгүүлч Жа.Пүрэвийн хийсэн энэ ярилцлага нь ур хийц, уншуулах чадвараараа “Үнэн” сонины алтан фондод шигшигдэн ялгарч ороод үүрд хадгалагдаж байгаа яруу сайхан ярилцлагуудын нэг мөн билээ.

“Үнэн” сонин сурвалжилга хэмээх жанрыг хөгжүүлсэн нь. “Үнэн” сонины 1945 оны 10-р сарын 22-ны өдрийн №242-т “Нэгэн сэтгэлгээ” нэртэй содон сурвалжилга нийтлэгджээ. Зохиогч нь БНМАУ-ын Соёлын гавьяат зүтгэлтэн, “Улаан наран” романаараа монголын ард түмний дунд алдаршсан ахмад сэтгүүлч Санжмятавын Дашдэндэв.

“Үнэн” сонины сурвалжлагч С.Дашдэндэв 1945 оны 10-р сарын 20-ны түүхт өдөр Монголын ард түмэн, түүний гол төлөөлөл болсон Улаанбаатар хотын иргэд Монгол Улсынхаа тусгаар тогтнолыг нэгэн сэтгэлгээгээр гарын үсэг зурж баталгаажуулсан түүхэн үйл явдлыг сурвалжлан бичиж үлдээжээ. “Өглөөний 6 цаг гэхэд хөдөлмөрчдийн өргөн жагсаал жигдэрч

тус тусынхаа гарын үсэг зурах төвд хүрч очсон байлаа” гэсэн үгсээр сурвалжилга эхэлж байна. Эхлээд Сүхбаатарын талбайн ойролцоох төв хэвлэх үйлдвэрээр С.Дашдэндэв сурвалжлагч орж олон хүн багтаж ядан дугаарлан зогсоод гарын үсгээ баяр баясгалантайгаар зурж буйг дүрслэн үзүүлжээ. Улмаар Худалдааны техникум, Гандан, Аж үйлдвэрийн комбинатаар залгуулан сурвалжилж хэн юу хэлж хэрхэн санаа бодлоо илэрхийлж байгааг яг л кино дэлгэцнээ гарах кино зураг адил дүрслэн буулгаж үзүүлсэн аж.

“Нэгэн сэтгэлгээ” хэмээх энэ сурвалжилгаас алс тэртээх 1945 оны 10-р сарын 20-ны өдөр нийслэл Улаанбаатар хотод болсон түүхэн чухал үйл явдал толинд буусан адил тодхон харагдаж Эх орон, тусгаар тогтнолоо гэсэн монголчуудын оргилох сэтгэл, булгилах зүрх нүдэнд үзэгдэж, чихэнд сонсогдох шиг болж байна. Сурвалжлагч болж буй үйл явдалд биеэр оролцож, ямар бодол сэтгэгдэл төрсөн, түүнийгээ уншигчдад яг тэр чигээр нь дамжуулан хүргэх үүрэгтэй.

Ингэж бичихийг сурвалжилга гэдэг бөгөөд “Үнэн” сонины сурвалжлагч С.Дашдэндэв сурвалжилгын жинхэнэ мастер байсан нь дээрх сурвалжилгаас маш тодорхой харагдаж байгаа юм.

“Үнэн” сонин сэтгүүл зүйн шүүмж судлалыг хөгжүүлсэн нь. “Үнэн” сонин зөвхөн мэдээ, сурвалжилга, ярилцлагын төрөл зүйлд төдийгүй урлаг, утга зохиол, сэтгүүл зүйн шүүмж шүүмжлэлд онцгой анхаарал хандуулж ирсэн байдаг. Үүний нэг тодорхой баримт бол урлаг судлалын нэртэй эрдэмтэн, алдарт зохиолч, ахмад сэтгүүлч Ч.Лодойдамбын “Үнэн” сонинд нийтлүүлсэн “Анхны үг” хэмээх театрын шүүмж болно.

Судлаач өөрийн шүүмждээ “Манай театр 1933 онд Д.Нацагдоржийн зохиосон “Учиртай гурван толгой” гэдэг бадагчилсан аялгуут жүжиг тавьж дуут жүжгийн эхийг тавьсан юм. Түүнээс хойш театрын хамт олон монгол ардын домог, үлгэр, ард түмний амьдралаас иш татсан үндэсний аялгуут жүжиг, дууриудыг туурвин бүтээсэн нь “Евгений Онегин”-д ирэх зам болов” гэсэн том дүгнэлтийг хийжээ. Монголын урлаг амжилттайгаар урагшлан хөгжиж дэлхийн сонгодог дуурийн нэг сувд эрдэнэ болсон “Евгений Онегин”-ыг өөрийн тайзнаа амилуулах хэмжээнд хүртлээ өсөж бойжиж эрийн цээнд хүрч чадсанаа батлан харууллаа хэмээн Ч.Лодойдамба уг шүүмждээ бахархан тэмдэглэжээ.

““Үнэн” сонин аян замын тэмдэглэлийг хөгжүүлсэн нь. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл дотор онцгой тод байр суурийг эзэлж монголчуудын сэтгэл зүрхийг байлдан дагуулж чадсан нэг бичвэр байдаг юм. Энэ бол тэмдэглэл. Монголын утга зохиол, нийтлэлийн түүхэнд ариун баялаг өв уламжлалтай аян замын тэмдэглэлийг “Үнэн” сонин өнгөрсөн зуун жилийн турш түүчээлэн хөгжүүлж ирсэн байдагтай олон хүн маргахгүй болов уу. Г.Дэлэг, Л.Түдэв, өвгөөдэй Дамдинсүрэн зэрэг нэрт мастеруудын аян замын тэмдэглэлүүд “Үнэн” сониноор дамжиж өргөн олон түмэнд хүрч байсан нь маргашгүй үнэн бодит баримт. Монголын олон арван нийтлэлчдийг чухамхүү тэмдэглэл хэмээх энэхүү торгомсог, тансаг сайхан бичвэр алдрын оргилд гаргаж, уран чадварынх нь хамгийн яруу тод илэрхийлэл болж үлдсэн түүхтэй. Жишээ баримтаар эл санаагаа тодруулж батлахыг хичээе.

Манай нэртэй сайн зохиолч, сэтгүүлч Д.Цэвэгмид “Алс өрнөд тивд” хэмээх тэмдэглэл бичиж 1961 онд “Үнэн” сонинд нийтлүүлжээ. Эл тэмдэглэл нь дотроо “Тэнгэрийн замаар”, “Нью-Йоркын онгоцны буудал дээр”, “Нью-Йоркын анхны шөнө”, “Бартаатай давааг давав”, “Хууль ёсны суудлаа эзлэв”, “НҮБ-д Монголын далбаа хийсэв” гэсэн үндсэн 6 хэсэгтэй. Үүнийг уншаагүй монгол хүн цөөхөн буй заа. БНМАУ олон саад бэрхшээлийг гэтлэн туулж тэмцэн зүтгэж байж (4 удаа өргөдөл гаргасан байдаг) Нэгдсэн Үндэстний Байгууллагад гишүүнээр элсэн орж хүн төрөлхтөн, дэлхийн улс орнуудад хүлээн зөвшөөрөгдсөн торгон мөчийн алтан агшныг товч тодорхойгоор тэмдэглэж үлдээсэн түүхэн шашдир бичлэг юм.

Би Д.Цэвэгмидийн “Алс өрнөд тивд” аян замын тэмдэглэлийн 6 хэсгээс эхний ба сүүлчийн хэсэг дэх нэгжгээд өгүүлбэрийг уншиж та бүхэнд сонордуулан сонирхуулахыг хүсэж байна. “Тэнгэрийн замаар” хэмээх эхний хэсэгтээ тэр бээр “Эх нутгийн хилийг давах үедээ эргэж дахин харлаа. Энхрий хайрт Монгол нутаг гэгээн цэлмэг тэнгэртэй, гэрэлт алтан нартай тэнгэр, газрын уулзвар тэртээ хол нээгдэж сүндэр сайхан уулсын сүүн цагаан орой нь гялалзана. Аглаг сайхан хээрийн алтан шар бүрхүүл нь туяарна” хэмээжээ. Бүрэн Эрхт Бүгд Найрамдах Монгол Ард Улсаа НҮБ-ын гишүүнээр элсүүлэх даалгавар аваад тэнгэрийн хүлэгт сууж алсыг зорин явж буй итгэлт хүүгийнх нь үнэн зүрхний үг юм. Элгэн халуун нутгаа эргэж нэг хараад эх орон, газар шороогоороо бахархан омогших сэтгэл төрж буйг зурвасхан боловч тодхон зурж дүрсэлж үзүүлжээ. Элэг зүрхнээс уяатай элгэн халуун нутаг, эцэг эхээс заяатай энхрий Монгол орон

нь түүнд эрч хүч, эрэмгий зоригийг бэлэглэж байна.

“НҮБ-д Монголын далбаа хийсэв” хэмээх сүүлчийн 6-р хэсэгт зохиогч 1961 оны 10-р сарын 31-ний өдрийн үйл явдлыг доорх байдлаар буюу “Эрт дээр цагаас эрх чөлөө, тусгаар тогтнолын ариун бэлэг тэмдэг болсоор ирсэн алтан соёмбо үсэгтэй, дундаа хөх тэнгэрийн өнгөтэй, хоёр тал нь гал улаан далбаа НҮБ-ын төв ордны өмнө бусад зуу гаруй улсуудын төрийн далбаануудын дунд намилзан мандах нь олноос онцгой-очтой туяатай, түмнээс түрүүнд гэрэлтэй гэгээтэй мэт бидэнд санагдаж байлаа” хэмээн сэтгэл хөдлөнгүйгээр мөнхлөн тэмдэглэж үлдээсэн байна.

“Алс өрнөд тивд” бол гайхалтай сайхан бүтээл. Тэмдэглэлийн эхлэл болоод төгсгөл хэсэг гойд сайхнаар зохицолдон сүлэлдэж агуулга, ач холбогдлыг улам товойлгон монгол хүн бүрийн эх оронч сэтгэлийн утсыг доргион хөдөлгөж, тусгаар тогтнолоороо омгорхон бахархахуйц хэмжээнд бичигджээ. Энэ бол эл тэмдэглэлийн хүмүүжүүлэх нөлөө гойд гоц болсныг харуулж байгаа юм. Ерөөсөө уг тэмдэглэлийн амин сүнс нь энэ гэж хэлж болно.

Энэхүү илтгэлдээ би “Үнэн” сонинд нийтлэгдсэн хэдэн зуу, мянган тэмдэг-лэлээс Д.Цэвэгмидийн “Алс өрнөд тивд”, Ц.Дамдинсүрэнгийн “Дайны үеийн өдрийн тэмдэглэл” хэмээх хоёр тэмдэглэлээр жишээлж авсан болно.

“Үнэн” сонин найрууллыг хөгжүүлэхэд нөлөөлсөн нь. Найрууллыг утга зохиол, сэтгүүл зүйн судлаачид утга зохиолын бага, сэтгүүл зүйн бичлэгийн дээд төрөл гэж тодорхойлдог. Учир нь сэтгүүл зүйн бичлэгийн бүх төрөл, зүйл дотроос баат-

рынхаа дүрийг бүтээдэг нь ганц найруулал юм. “Үнэн” сонин Монголд найруулал хэмээх бичлэгийг хөгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн байдаг билээ.

Их эрдэмтэн зохиолч, сэтгүүлч Бямбын Ринченгийн “Их говийн зоригтон хүмүүс” найрууллыг авч үзье. Эл найруулал “Үнэн” сонинд нийтлэгдэж, үе үеийн олон сэтгүүлч бичлэгийн арга барилаас нь суралцаж ирсэн түүхэн уламжлалтай юм.

1 944 оны 12 дугаар сарын хавсаргатай нэгэн шөнө Хэнтий, Төв, Дорноговь, Дундговь аймгийн нутгийг хамарсан их цасан шуурганд далан мянган адуун сүрэг уруудан туугдаж улсын хил даван алга болох үзэгдэж харагдаагүй аюул нүүрлэхэд монголын говийн эрэлхэг малчин Балдан, Дамбадаржаа нар хэрхэн цасан шуургатай тэмцэж адуун сүргийг тогтоон барьсан тухай уг найруулалд өгүүлж байна.

Зохиогч “тэр хэсэг ардууд өдөр шөнийн турш өчнөөн морь юулж давхисаар явган шуурган дундуур гурван өдөр гурван шөнө морины нуруун дээрээс буулгүй, нойргүй тэр олон адуутай ноцолдов” гэжээ. Эх сайхан монгол хэлээрээ үйл явдлыг нүдэнд үзэгдэж, сэтгэлд хоногштол тов тодорхой буулган хэлжээ. Үгийг онож хэрэглэх гэдэг бол нийтлэлчийн уран чадварын тод хэмжүүрийн нэг. Энд “ноцолдов” гэсэн үг нүдэнд онцгой содон тусаж, үйл явдлын агуулгыг тархинд гайхалтай тод томруун буулгаж байна. Байгаль дэлхийн аймшигт үзэгдэл болох нүүр нүдгүй шуурах цасан шуурганд туугдсан зах хязгааргүй адуун сүргийг хил давуулалгүй тогтоон барих гэж Балдан, Дамбадаржаа нарын малчин ардууд гурван өдөр, гурван шөнө морины нуруун дээрээс буулгүй

тэр олон адуутай ноцолджээ. Ноцолдов гэдэг үг тулалдав гэсэнтэй яг адилхан сонсогдож байгаа юм.

Байгаль, хүн хоёрын тулалдааныг үгээр урлан дүрслэхдээ их Ринчен гуай ноцолдов гэдэг үгийг зориуд сонгон хэрэглэжээ. Тийнхүү цасан шуургатай тулалдаж байх “завсар салхинд уруудуулан алдсан адууныхаа мөрөөр хэдэн зуун километрийн газраас замнасан, даарсан бээрсэн, ядарсан зовсон эрэлчин дээр дээрээсээ ирцгээв. Өлсөж зовсон эрэлчин замдаа тохиолдсон үхсэн малын махыг идэж, цас хайлуулан ундалж явсан зовлонгоо тоочин ярив” гэжээ.

“Дээр дээрээсээ ирцгээв”, “даарсан бээрсэн, өлсөж зовсон” хэмээн эрэлчдийг хүч оруулан тодотгоод зам зуурт тохиолдсон зовлонгоо “тоочин ярив” гэж өгүүлбэрээ зангидсан байна. “Тоочин” гэсэн энэ үг ноцолдов гэдэгтэй яг адилхан яв цав зохицон нийцэж агуулгыг асар ойлгомжтойгоор илэрхийлэн гаргаж чадсан байна. Зүйрлэн хэлбэл “ноцолдов”, “тоочин ярив” зэрэг үгс нь сийлбэрлэн урласан уран бүтээл адил эл найрууллыг шигтгэн чимжээ.

“Хэдэн түмэн адуутай шөнө нойргүй ноцолдож байхад Дамбадаржаагийн гэрийн нэгэн зөөлөн сэтгэлт авгай холоос өлсөж даарч ирсэн эрэлчин зочдод халуун хоол хийж өгөх гэж өдөр шөнөгүй галаа өрдөж, тогоогоо гал дээрээс авах чөлөөгүй байв. Хаврын тарчиг цагт хэрэглэх гэж дулаан намраас бэлтгэсэн аргал түлш, идээ хоол нь барагдах шахав” хэмээн найруулал цааш үргэлжилжээ. Говийн сайхан сэтгэлт хүмүүсийн хүнлэг энэрэнгүй зан төрхийг дээрх авгайн дүрээр ийнхүү товойлгон гаргажээ. “Тогоогоо гал дээрээс авах чөлөөгүй”-гээр тэр авгай сэтгэл гарган зүтгэж

“аргал түлш, идээ хоол нь барагдах шахав” гэсэн нь уншигчдыг өөрийн эрхгүй уяруулж байнам бус уу.

Хэлж ирдэггүй хийсэж ирдэг байгалийн гамшиг гэдэг юутай аймшигтай агаад бэрх хатуу, хайр найргүй үзэгдэл болохыг “Үхсэн адууныхаа дэргэд даага сарваа, үхсэн даага сарвааныхаа дэргэд эх нь зогсоцгоон гашуунаар унгалдан янцгааж байв. Говьд үзэгддэггүй нэгэн айхавтар сагсгар сүрхий амьтан говийн номхон амьтдыг цочоон үргээж хэвтэж байсан нь сагсгар их сүүлтэй, дэрвийсэн их хар эвэртэй сарлагийн бух үхсэн адууны дэргэд хэвтэж байсан гэдэг. Тэр сарлагийн бух уруудсан олон адуунд түрэгдэн автагдаад бухын зүрх нь олон адууны ширүүн их гүйдлийг даалгүй үнхэлцэг нь хагарчихсан байжээ. Тэгээд ч тогтож торохгүй давхиж явсан, уруудсан тэр олон адуу сарлагийн тэр үхсэн бухыг хавчин явсаар байжээ” хэмээн дүрслэн үзүүлсэн байна.

Энэ мэт сэтгүүл зүйн бичлэгийн бүх төрөл, зүйлээр мэргэжлийн өндөр түвшинд бичигдсэн олон зуу, мянган шилдэг бүтээл “Үнэн” сонинд нийтлэгдэж нийтийн хүртээл болсон байна. Тэр хэмжээгээр эдгээр бичлэг үе үеийн залуу сэтгүүлчдэд гарын авлага, үлгэр дуурайл болж байсан аж. Үүнийг баталж нотлох тод баримт бол “Монголын шилдэг нийтлэл” цуврал 99 боть юм.

“Монголын шилдэг нийтлэл” цуврал 99 ботид “Үнэн” сониныхны бүтээлүүд хамгийн олноор багтжээ. “Монголын шилдэг нийтлэл” цуврал 99 ботийн анхны ботийг аугаа их соён гэгээрүүлэгч, Монголын орчин үеийн сэтгүүл зүйг үндэслэгч Жамсрангийн Цэвээний нийтлэлүүдээр эмхэтгэн гаргасан бол хоёр дахь ботийг түүний хамтран зүтгэгч Догсомын Бодоо,

хошой гүн Бадрахбаатар, Бунибазарын Дорж нарын бүтээлүүдээр түүвэрлэсэн. Залгуулаад Сономбалжирын Буяннэмэх, Дашдоржийн Нацагдорж, Цэндийн Дамдинсүрэн, Дондогийн Цэвэгмид нарын зэрэг нэрт нийтлэлчдийн нийтлэлүүдийг эмхэтгэж, нарийвчилсан судалгааны бүтээлүүдээр хавсарган баяжуулаад хэвлэж байгаа болно.

“Үнэн” сонинд ажиллаж хөдөлмөрлөж, бүтээж туурвиж ирсэн уран бүтээлчдээс Ц.Намсрай, Г.Дэлэг, М.Цэрэнжамц, Г.Жамц, Д.Цоодолоос эхлээд С.Жамбалдорж, Г.Дамба, Х.Лхамдорж, Ц.Мишигдорж, Т.Баасансүрэн, Ц.Мөнхбаатар, А.Даваасамбуу, Б.Ганбат, Б.Ганболд, Жа.Пүрэв, Х.Цэвлээ, Г.Бямбажал, Ш.Цэен-Ойдов, С.Лочин, Д.Дорждулам, Н.Шарав-Иш, А.Цэрэннадмид, Г.Далантай, Ч.Батсүрэн, Д.Үржинбадам нарын зэрэг олон хүний шигшмэл нийтлэлүүд “Монголын шилдэг нийтлэл” цувралд ботилогдон орж, өөрсдийн байр суурийг эзлэн их, дээд сургуулиудын сэтгүүл зүйн ангид суралцагч оюутнууд гарын авлага болгон ашиглаж дадлагажин, тэрчлэн сэтгүүл зүйн залуу судлаачдын судалгааны хэрэглэгдэхүүн болж байгааг хэлэхэд надад маш таатай байна.

Миний бие сүүлийн гучаад жилд Монголын сэтгүүл зүйн салбар, түүний дотор “Үнэн” сонинд ажиллаж хөдөлмөрлөж, бүтээж туурвиж ирсэн үе үеийн олон арван уран бүтээлчийн нийтлэлд шинжилгээ хийсэн байна. Тухайлбал Жамсраны Цэвээн, түүний хамтран зүтгэгч Догсомын Бодоо, хошой гүн Бадрахбаатар, Бунибазарын Дорж нарын нийтлэлийг тусгайлан судалсан байна.

“Сономбалжирын Буяннэмэхийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ”² хэмээх нэртэй

нэг сэдэвт зохиол бичиж ном болгон хэвлүүлжээ. “Монголын үнэн” сонины анхны 6 дугаарын бүх нийтлэлд нарийвчилсан ажиглалт шинжилгээ хийж “1921 оны ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил” номынхоо “Монголын үнэн” сонин нийгмийг өөрчлөн шинэчлэх хувьсгалт тэмцэлд уриалан дуудсан нь”³ хэмээх нэгдүгээр бүлгийг, тэрчлэн Монголд нэг нийгэм нөгөөгөөр солигдох үеийн буюу өнгөрсөн зууны дал наяд оны “Үнэн” сонины үйл ажиллагаа, нийтлэлд ажиглалт шинжилгээ хийж “1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв” номынхоо “Үнэн” сонин ардчилал шинэчлэлийн салхийг үүсгэн сэвэлзүүлсэн нь” хэмээх бүлгийг тус тус бичиж гаргасан байна. “Монголын үнэн” сонин ба Монголын чөлөөт хэвлэлийн тухай” гэсэн сэдвээр тусгайлан судалгаа хийж эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж байж.

“Үнэн” сонинд ажиллаж, бүтээл туурвилаа хэвлүүлж явсан Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, М.Бизьяа, С.Дашдэндэв, Н.Циенжав, Л.Түдэв, өвгөөдэй Дамдинсүрэн, Д.Нямаа, С.Жамбалдорж, Ц.Дашдондов, Ц.Балдорж, Ш.Цэрэнпил, Ш.Цэен-Ойдов, Г.Жамц нарын зэрэг олон уран бүтээлчийн лаборатори руу өнгийн харж, тэдний бичлэгийн арга барил, ур чадварын өвөрмөц онцлогийг нь олж харж нээж үзүүлэхийг хичээж байжээ.

Өөрийн ухамсарт бүх амьдралаа “Үнэн” сонинд зориулсан Ц.Намсрай, Г.Дэлэг нарын сэтгүүлчийн үйл ажиллагааг судалж, Монголын сэтгүүлчдийн байгууллагын анхны дарга нь “Үнэн” сониноос төрж гарсныг тэмдэглэж, энэ сониныхон Монголд мөшгөх сэтгүүл зүй буюу эрэн сурвалжлах чиглэлийг анхлан нэвтрүүлж хөгжүүлэх

эхлэл тавьсныг баримтаар баталгаажуулж дурдсан байх юм.

“Үнэн” сонинд олон жил үр бүтээлтэй ажиллаж “Нөхөр Валентин” зэрэг нийтлэлийн ном гаргасан Г.Дамбын тухай “Үнэн” сонины Дамба”, “Хүмүүс” хэмээх нийтлэлийн нэрд гарсан өвөрмөц содон бүтээлийн ном туурвисан Л.Түдэвийн тухай “Эх орон, хүн ардын тухай дуулал”, Ш.Цэрэнпилийн “Хэнээт” хэмээх хөрөг найрууллын талаар “Баримтаас дүр бүтээх ёсон”, Ц.Балдоржийн “Мананг арилгалаа” мэдээг задлан шинжилсэн “Сэтгүүл зүйг баяжуулав. Хойч үе үнэлнэ”, Ц.Дашдондовын уран бүтээл, чөлөөт хэвлэлийн төлөөх тэмцлээр “Чөлөөт ардчилсан хэвлэлийн загалайлсан эцэг”, С.Жамбалдоржийн “Морин эрдэнэ”, “Тэмээ тэнгэрийн амьтан” ном, бусад нийтлэлийнх нь талаар “Энциклопеди Жамбалдорж буюу танин мэдүүлэгч сэтгүүлч”, Хорлоогийн Цэвлээгийн “Миний сэтгүүл зүй” ном, уран нийтлэлүүдийнх нь тухай “Сэтгүүлчдийн ширээний ном бичсэн хүний тухай өгүүлэх нь”, Ш.Цэен-Ойдовын “Нарны тоост гурвалжин” номоор “Хос мэргэжил эзэмшихийн хосгүй давуу тал”, нэрт нийтлэлч Б.Ганбатын эсээ нийтлэлүүдийг задлан шинжилсэн “Эх” ба “Эцэг” эсээг зохиогчийн уран чадварын тухай өгүүлэх нь”, “Цаст Алтайн чуулган” номыг туурвигч Б.Монголхүүгийн уран бүтээлээр “Ганц дайчин ганцаарддаггүй юм байна”, нийтлэлч А.Даваасамбуу Ж.Саруулбуян нарын “Монгол адууны тамгын ойллого” номын тухай “Тамга болоод бөх судлаач сэтгүүлчдийн зарим нийтлэлийг сонжин шинжихүй”, Г.Гонгоржавын “Монголчуудын эрдэм ухааны уламжлал” номын тухай “Сэтгүүл зүйн шинэ жим харгуй гаргагчийн тухай тэмдэглэн хэлэх цөөн

үг”, сэтгүүлч Р.Чулууны “Алтайн хөх харуул”, бусад ахмад сэтгүүлчдийн бүтээлээр “Хур мэт асгаранхан буух ахмадуудын бүтээл ундартугай” зэрэг тусгайлсан шүүмж судлалын өгүүллүүдийг бичиж хэвлүүлж байжээ.

“Монголын үнэн” сонин Монголд чөлөөт сэтгэлгээг дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулсан нь. “Үнэн” сонины үе үеийн шилдэг нийтлэлчдийн уран бүтээлийн ур чадварын талаар энэ мэтээр үргэлжлүүлэн ярих гэвэл хэдэн арав, зуун хуудсаар өгүүлэн хүүрнэх хэрэгтэй болно. Алтан үеийнхэн, ахмад үе, дунд болоод өнөө үеийнхний хэдэн зуу, мянган нийтлэлийг нэр дурдаж нэрлэн задалж шинжих шаардлага гарна. Би энд төлөөлүүлж цөөхөн хэдэн жишээг иш татаж ярив.

Сэтгүүл зүй бол нийгмийн шинжлэх ухааны нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг, өөрийн гэсэн өвөрмөц өнгө төрх, үндсэн үүрэг, зорилго, зарчимтай, үүсэл, хөгжил, төлөвшлийн тов тодорхой үе шатуудыг дамжин хөгжиж төлөвшдөг бие даасан шинжлэх ухаан юм.

Сэтгүүл зүйн хөгжил төлөвшил нь зогсонги, царцанги байдлыг хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй. Байнгын хөгжил хөдөлгөөн, хувьсал дэвшилд оршин хөгжиж боловсронгуй болж байдаг. Үүний хамгийн тод томруун илэрхийлэл нь үе үеийн сэтгүүлчдийн бичлэгийн арга барилын илэрхийлэл буюу нийтлэл зүйн төрөл, зүйлийн хөгжил дэвшил, хувьсал шинэчлэл юм.

“Монголын үнэн” сонин үүсэн буй болоод хөгжин дэвшиж ирсэн өнгөрсөн нэг зуун жилийн хугацаанд эл үйл явц хэзээ ч лаг шаварт сууж зогсож гацаж байсангүй. Ямагт урагшилж тэмүүлэн тэлж хүрээгээ өргөжүүлэн хөгжүүлж иржээ. Зарим он жилүүдэд илүү түргэн хурдацтай, заримдаа

харьцангуй удаавтар алаг цоог байсан байж болно. Энэ нь тухайн цаг үеийн дэлхий дахины ерөнхий төлөв байдал, хүн төрөлхтний аж амьдралыг доргиож нөлөөлөхүйц нийтийг хамарсан дайн дажин, хүчирхийлэл зэрэг томоохон үйл явдал, улс орны хөгжил дэвшлийн онцлог үе шатуудтай холбоотой агаад жич судалж үзүүштэй асуудал юм.

Харин Монголын сэтгүүл зүй, өөрөөр хэлбэл “Үнэн” сонинд ажиллагч чадварлаг сэтгүүлчдийн бичлэгийн арга барил, ур чадвар хумигдан мухардалд орж хөгжил хөдөлгөөн нь гарцгүй болж гацаж зогссон, ухарсан нь үгүй юм. Удаавтар боловч урагшилсаар, улам хөгжин боловсронгуй болсоор өнгөрсөн зууны ерээд онтой золгожээ.

“Үнэн” сонин нийгмийн амьдралд гарч буй тэргүүний дэвшилтэй юм бүхнийг сурталчлан дэлгэрүүлж, улс орны хөгжилд чөдөр тушаа бологч хоцрогдол бүртэй тууштай тэмцэж ирсэн байна. Энэ бүхэн нь тус сонины өнгөрсөн зуун жилийн шарласан хуудсуудаас нэн тод харагдаж байгаа юм.

Шинжлэх ухааны шинэ ололт амжилт, соёл, боловсрол, эрүүл мэнд, мал аж ахуй, газар тариалан, үндэсний аж үйлдвэрлэлийн үүсэл, хөгжил, дав-

шилт, хамтын хүчний давуу тал, соёлын довтолгоон, атар газар эзэмших удаа дараагийн аян, Монголд нэг нийгмийг нөгөөгөөр сольж өөрчлөх тэмцэл хөдөлгөөний үүх түүх - бүгд “Үнэн” сониноос нэвт үнэртэж, шууд мэдрэгдэж, гарт баригдаж байна.



“Үнэн” сонин нийгмийн амьдралд гарч буй тэргүүний дэвшилтэй юм бүхнийг сурталчлан дэлгэрүүлж, улс орны хөгжилд чөдөр тушаа бологч хоцрогдол бүртэй тууштай тэмцэж ирсэн байна.

Энэ бүхэн нь тус сонины өнгөрсөн зуун жилийн шарласан хуудсуудаас нэн тод харагдаж байгаа юм.

Шинжлэх ухааны шинэ ололт амжилт, соёл, боловсрол, эрүүл мэнд, мал аж ахуй, газар тариалан, үндэсний аж үйлдвэрлэлийн үүсэл, хөгжил, давшилт, хамтын хүчний давуу тал, соёлын довтолгоон, атар газар эзэмших удаа дараагийн аян, Монголд нэг нийгмийг нөгөөгөөр сольж өөрчлөх тэмцэл хөдөлгөөний үүх түүх бүгд “Үнэн” сониноос нэвт үнэртэж, шууд мэдрэгдэж, гарт баригдаж байна



чөлөөт сэтгэлгээний төв индэр нь болж ирсэн түүхэн замналтай хэвлэл юм гэдгийг онцлон тэмдэглэж хэлье. Эдгээр нь дээр дурдсан судалгаануудаар нотлогдож байгаа болно.

Үүний хамгийн тод хөдөлшгүй том баримт бол 1921 онд Монголд Ардын хувьсгалыг мандуулахын төлөө хийсэн “Монголын үнэн” сонины 6 дугаарын цогтой тэмцэл, түүний бодит үр дүн ба өнгөрсөн зууны наяд оны үеийн “Үнэн” сонины өөрчлөн байгуулалтын өргөн дэлгэр сэдэв, ил тод байдал, олон ургалч үзлийн давлагаа, 1990-ээд оны ардчилсан хувьсгалыг ялуулахын төлөө “Үнэн” сониноос явуулсан нийтлэлийн бодлогын тов тодорхой хэрэгжилт юм. Өөрөөр хэлбэл “Үнэн” сонин цаг ямагт, ялангуяа нийгмийн огцом шилжилтийн он жилүүдэд монголчуудын дуу хоолой, монголын нийгмийн

Дүгнэлт

1. Монголд сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлийг үүсгэж хөгжүүлэн төлөвшүүлэхэд “Монголын үнэн” буюу “Үнэн” сонин нь үнэхээрийн том буюу голлох гавьяаг байгуулжээ.
2. Шинэ Монгол Улсын үе үеийн нийтлэлчдийн өсөж хөгжих, дээшилж дэвжих жинхэнэ талбар нь өдөр тутмын “Үнэн” сонин байжээ. Монголын сэтгүүл зүйд “Үнэн” сонин “бичлэгийн бүхэл бүтэн дэг жаяг” буй болж, тэр нь сэтгүүлчдийн ур чадварыг тодорхойлж тэргүүлэгч, чиглүүлэгч хүчин зүйл болж нөлөөлж иржээ гэж бүрэн үндэстэй хэлж болохоор байна.
3. ХХ зууны Монголд хоёр хувьсгалыг мандуулахад (1921 ба 1990 оны) хосгүй гавьяа байгуулсан “Үнэн” буюу “Монголын үнэн” сонин нийгмийн амьдралд шинжлэх ухааны ололт амжилт, шинэ дэвшилт зүйл бүхнийг түгээн дэлгэрүүлж соён гэгээрүүлж танин мэдүүлэх үүргээ хэрэгжүүлэх явцдаа хэзээ ямагт чөлөөт сэтгэлгээний төв индэр нь байж Монгол Улсад чөлөөт сэтгэлгээг, түүний дотор чөлөөт бичлэг, улмаар чөлөөт хэвлэлийн зарчмыг хөгжүүлэхэд өөрийн жинтэй хувь нэмрээ оруулж чадсан байна.

Эшлэл

- ¹ “Үнэн-20000” (Эмх. Х.Цэвэлээ). УБ., 2004 үзнэ үү.
- ² Баасансүрэн Т. Сономбалжирын Буяннэмэхийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ. УБ., 2020. III бүлэг.
- ³ Баасансүрэн Т. 1921 оны Ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил. УБ., 2009. I бүлэг.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Т.Баасансүрэн. 1921 оны Ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил. Дэд дэвтэр. УБ, 2009
2. Т.Баасансүрэн. 1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв. Гутгаар дэвтэр. УБ. 2009
3. Т.Баасансүрэн. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь. Дөтгөөр дэвтэр. УБ. 2009
4. Т.Баасансүрэн. Монголд чөлөөт хэвлэл “устах” аюул нүүрлэж байна. Зургаадуугаар дэвтэр. УБ. 2016
5. “Үнэн-20000” эмхэтгэл. УБ. 2004
6. Т.Баасансүрэн. Монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүл зүйн шүүмж судлал, тулгамдсан зарим асуудал. УБ. 2020
7. Л.Норовсүрэн, Т.Баасансүрэн, Б.Уянга. Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: сэтгүүл зүйн нэрт судлаач Гэндэнжамцын Дэлэг. УБ, 2013.

Резюме

Автор в статье, посвященной 100-летию первой революционной газеты Монголии “Монголын үнэн” или “Үнэн” на основе многолетних исследований и редких материалов газеты показывает ее роль и значение в развитии жанров периодической печати и повышении мастерства журналистов Монголии. Автор делает вывод о том, что газета “Үнэн” не только сыграла особую роль в победе двух революций в Монголии ХХ века (1921 и 1990 гг.), но и в процессе выполнения своих познавательной, просветительской функций всегда была трибуной свободного мышления и внесла большой вклад в развитие принципов независимой прессы в Монголии.